  - Суудлын автомашин, автобусны дундаж ачаалалтай үеийн 100 км гүйлтэд зарцуулах шатахууны хэмжээ л/100 км
  - Тусгай зориулалтын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны хэмжээ л/100 км
- 1.5.2. Энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын 2,4 дүгээр хүснэгтийн 1 дүгээр хэсэгт зааснаар ачаа тээврийн автомашины 100 тн.км тээврийн ажил гүйцэтгэхэд зарцуулах шатахууны нормыг тооцно.
- 1.5.3. Автомашины ашиглалтын нөхцөлөөс хамааруулан олгох шатахуун зарцуулалтын үндсэн нормын нэмэгдлүүд. Үүнд:
- Авто замын нөхцөлийн нэмэгдэл (ашиглалтын бүсийн нэмэгдэл)-  $K_s$
  - Хүйтний улирлын нэмэгдэл-  $K_x$
  - Тээврийн ажил үйлчилгээний онцлогийг тусгасан нэмэгдлүүд-  $K_T$

## 2. Автомашины үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлийг тооцох аргачлал

### 2.1. Хүйтний улирлын нэмэгдэл- $K_x$ тооцох коэффициент

Монгол орны нутаг дэвсгэрийг хүйтний 3 бүсэд хуваан, бүсийн хилийг сумдын хилээр тогтоож, түүнд харьяалагдах аймаг, сум, олгох нэмэгдлийн хэмжээ, мөрдөх хугацааг энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын хүснэгт 2,1-т тусгав.

Хүйтний улиралд автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх ба бууруулах хувь хэмжээг ( $K_x$ ) дараах томъёогоор тодорхойлно:

$$K_x = \frac{\pm \Pi}{100\%}; \quad [3]$$

Энд:


$\Pi$  - хүйтний улирлын нэмэгдлийн хэмжээ, %

Автомашины үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь хэмжээг зөвхөн тухайн бүсэд ажилласан автомашинд олгоно.

Хот хооронд болон орон нутгийн чиглэлд тээвэрлэлт хийж буй автомашин хүйтний бүс дамжин өнгөрвөл II бүсийн нэмэгдлээр тооцож олгоно.

### 2.2. Авто замын нөхцөлийн нэмэгдэл (ашиглалтын бүсийн нэмэгдэл)- $K_s$ тооцох коэффициент

Авто замын өндөршилт, хучилтын байдал, хөрсний бүтэц, нэг хавтгай дөрвөлжин км талбайд ногдох бартааг гол үзүүлэлт болгон тус орны нутаг



дэвсгэрийг авто замын нөхцөлөөр бүсэд хувааж бүсийн хилийг сумдын хилээр тогтоож, энэ тушаалын 2 дугаар хавсралтын хүснэгт 2.1.-д үзүүлэв.

Авто замын өндөршилт, далайн түвшнөөс дээш 1000-1500 метрт орших харьцангуй бага бартаатай нутгийн хөрсөн замд шатахууны үндсэн нормыг нэмэгдүүлэхгүй ба хорогдуулахгүй, далайн түвшнөөс дээш 1000-1500 метрт орших боловч нэг хавтгай дөрвөлжин км талбайд ногдох бартаа ихтэй нутагт ажиллах автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг 5%, далайн түвшнөөс дээш 1500-2000 метрт орших нутагт 10%, далайн түвшнөөс 2000 метрээс дээш орших ба элсэрхэг хөрстэй нутагт 15%-иар тус тус нэмэгдүүлж тооцно.

Автомашины шатахууны үндсэн нормыг далайн түвшнөөс дээш 500-1000 метрт орших нутгийн хөрсөн замд 5 хувь 500-1000 метрт орших хот хоорондын хатуу хучилттай замд 10 хувиар тус тус хорогдуулан тооцно.

Авто замын нөхцөлөөс хамааруулж автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх ба бууруулах хувь хэмжээг  $K_3$  дараах томъёогоор тодорхойлно:

$$K_3 = \frac{\pm \Pi}{100\%} \quad [4]$$

Энд:

$\Pi$  – Авто замын нөхцөлөөс хамааруулж шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх ба хорогдуулах хувь /нэмэгдүүлэхэд эерэг утгыг, хорогдуулахад сөрөг утгыг хэрэглэнэ/

Авто замын нөхцөлийг тооцох дундаж коэффициент:

$$K_3 = \frac{\sum_{i=1}^n S_i K_i}{\sum_{i=1}^n S_i} \quad [5]$$

Энд:

$K_i$  - бүс тус бүрийн авто замын нөхцөлийн коэффициент



$S_i$  - бүс тус бүрт автомашины явсан гүйлт, км

$n$  - тооцоонд орсон бүсийн тоо

### 2.3. Тээврийн ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцөлийг тусгасан нэмэгдлийг- $K_7$ тооцох коэффициент

Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нэмэгдлийн хэмжээ, олгох нөхцөлийг энэ тушаалын 2 дугаар хавсралтын хүснэгт 2,3-т үзүүлэв.

Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцөлөөс хамааруулж автомашины 100 км гүйлтэд зарцуулагдах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хэмжээг  $K_7$  дараах томъёогоор тодорхойлно:



$$K_T = \frac{\pm \Pi}{100\%}; \quad [6]$$

**Энд:**

$\Pi$  - тусгай нэмэгдлийн хэмжээ, %

1. Автомашины 100 тн.км тээврийн ажлын нормыг  $H_w$  дараах томъёогоор тодорхойлно:

$$H_w = H_{\text{тнкм}} * \frac{W}{100}; \quad [7]$$

**Энд:**

$H_w$  – автомашины тнкм-ийн ажилд олговол зохих шатахууны нэмэгдэл

$H_{\text{тнкм}}$  - автомашины хөдөлгүүрээс хамааруулан 100 тн.км тээврийн ажилд олговол зохих шатахууны хэмжээ

$W$  – автомашины хийсэн ажлын хэмжээ буюу бүтээл

$$W = G * S; \quad [8]$$

**Энд:**

$G$  - ачааны хэмжээ, тн

$S$  - гүйлт, км

### 3. Автомашины шатахуун зарцуулалтыг тооцон олгох аргачлал, зөвлөмж

Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох аргачлал, заавар, зөвлөмжийг автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэд шатахуун зарцуулалтын нэгжийн норм, хэрэгцээг төлөвлөх, тогтоох, нэмэгдүүлэх, хорогдуулах, шатахуун зарцуулалтын хэмжилт туршилт хийхэд ашиглаж болно.


Автотээврийн салбарын ажил, үйлчилгээг эрхлэхэд шатахуун, тослогооны материалын хэрэгцээг үнэн зөв тогтоох, зохистой зарцуулах, тогтоосон нормыг мөрдөж ажиллах нь чухал ач холбогдолтой юм.

Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хэмнэсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан тогтоосон нормоос шатахуун хэмнэсэн жолоочид хэмнэлтийн тодорхой хувиар шагнал олгох юмуу бусад урамшуулал үзүүлж болно. Энэхүү шагнал урамшуулал олгох журмыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага гаргана.

Автомашин бүхий аж ахуйн нэгж байгууллага, иргэд автомашины шатахуун зарцуулалтыг тооцож олгохын тулд тухайн автомашины үйлдвэрлэгчээс тогтоосон хяналтын норм, ашиглалтын нөхцөлийг тусгасан жишиг нормыг үндэс болгодог.

Энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтад багтсан автомашинуудын шатахуун зарцуулалтын жишиг нормыг шинэчлэн тогтоохын тулд Монгол Улсын автопаркын бүтцэд 10-аас дээш тоогоор ашиглагдаж байгаа, 2007 оноос хойш

26



— 200 370

үйлдвэрлэгдсэн нийтийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа автомашинуудыг сонгон авсан болно.

Шатахуун зарцуулалтын жишиг норм тогтоогдоогүй марк загварын автомашины хувьд автомашины үйлдвэрлэгчийн тогтоосон хяналтын норм болон ашиглалтын нөхцөлөөс хамаарч шатахуун зарцуулалтын өөрчлөлтийн хэмжээг илэрхийлэх коэффициентын тусламжтайгаар тооцооны аргаар тогтоож болно. (Энэхүү хавсралтын Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлалаас Томъёо [1]).

Автомашины шатахуун зарцуулалтын хяналтын нормыг (л/100 км) автомашин үйлдвэрлэгчээс тогтоож тухайн автотээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолт, ашиглалтын зааварт тусгасан байдаг. Автомашины шатахуун зарцуулалтыг ашиглалтын нөхцөлөөс хамааруулан өсгөх коэффициентыг тээврийн эрдэм шинжилгээний байгууллагын /К<sub>н</sub>/ судалгаагаар тогтоосон болно.

Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд боломжтой гэж үзвэл үндсэн нормоор нь шууд мөрдөх, эсвэл тодорхой хугацаанд тухайн автомашины шатахуун зарцуулалтад хэмжилт, туршилт явуулсны үндсэн дээр өөрийн ажил, үйлчилгээний онцлог, авто замын болон цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх ба хорогдуулах замаар үндсэн норм болгож мөрдөж болно.

Шатахуун зарцуулалтын сорил, туршилтын ажлыг гүйцэтгэхийн тулд автомашины техникийн байдлыг оношилж, шатахуун зарцуулалтад нөлөөлөх эвдрэл, гэмтэлгүй гэдгийг тогтоосон тохиолдолд сорил, туршилтын ажлыг хийж, бодит зарцуулалтыг тогтооно.

Автомашины тээврийн ажилд олгох шатахуун зарцуулалтын хэмжээ нь автомашины үндсэн норм, холбогдох нэмэгдлүүд (авто замын нөхцөлийн, хүйтний улирлын, тээврийн ажил үйлчилгээний онцлогийн г.м)-ээс бүрдэнэ.

Суудлын автомашин, автобус, ачааны такси, ахуйн тээврийн ачааны автомашин зэрэг гүйцэтгэсэн тээврийн ажлыг нь тн.км-ээр тооцох боломжгүй автомашины шатахууны нормыг дараах томъёогоор тооцно.



$$Q_n = N_v \times \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i) \quad [9]$$

Энд:

*K<sub>n</sub>* – автомашинд тухайн нөхцөлд олговол зохих шатахууны нэмэгдлүүд

Гүйцэтгэсэн ажлыг тн.км-ээр үнэлэх боломжтой ачааны автомашины шатахуун зарцуулалтын нормыг дараах томъёогоор тооцно.

$$Q_n = N_v \times \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i) + N_{тн.км} \times \frac{W}{100} \quad [10]$$



### 3.1. Автомашины шатахуун зарцуулалтыг тооцох жишээ бодлого

Автомашины шатахуун зарцуулалтыг тооцохын тулд дараах дарааллыг баримтална. Үүнд:

#### 1. Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм тооцох.

Жишээнд орж байгаа зарим тоо, үзүүлэлт нь хийсвэр бөгөөд зөвхөн аргачлалыг тодорхой болгох зорилгоор оруулсан болохыг анхаарна уу.

**Жишээ 1.** Аж ахуйн нэгж байгууллагын албан хэрэгцээнд ажиллах 1497 см<sup>3</sup> хөдөлгүүрийн багтаамжтай, 2012 онд үйлдвэрлэсэн бензин хөдөлгүүр бүхий Toyota Allion маркийн автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм нь энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтад 100 км гүйлтэд 7.5 л шатахуун зарцуулахаар заасан байна.

Хэрвээ уг автомашины шатахуун зарцуулалт жишиг норм нь уг тушаалд ороогүй бол хавсралт 3-ын томъёо [1]-ыг ашиглан жишиг нормыг тооцно. Toyota Allion маркийн автомашины хяналтын нормыг 100 км гүйлтэд 6.0 л, ашиглалтын нөхцөлийн коэффициентийг суудлын автомашинд 1,1-1,2 гэсэн өгөгдлийг ашиглан жишиг нормыг тооцвол;

$$N_{\text{жишиг}} = N_{\text{хяналт}} * K_{\text{о}} = 6,0 * 1,2 = 7,2 \approx 7,5 \text{ л}$$

#### 2. Автомашины жишиг нормыг тодорхой хугацаанд хянан автомашины үндсэн нормыг тогтоож мөрдөх.



Автомашины үндсэн норм нь тухайн автомашинд мөрдөх норм бөгөөд жишиг нормыг хянан үзэж бодит зарцуулалтыг үндэслэн жишиг нормыг бага зэрэг нэмэгдүүлэх эсвэл хорогдуулж тогтоож болно

**Жишээ 2.** Toyota Allion маркийн автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтад орон нутгийн замд 100 км гүйлтэд 7,5 л, Улаанбаатар хотын хөдөлгөөний эрчим ихтэй замд 9,0 л зарцуулахаар заасан бөгөөд Улаанбаатар хотын авто замын ачаалал буюу хөдөлгөөний эрчмийн нэмэгдлийг тооцсон норм байна.

Уг автомашины жишиг нормыг хянаж үндсэн норм болгон мөрдөхийн тулд тухайн байгууллага тодорхой хугацаанд шатахуун зарцуулалтын судалгааг хийнэ.

Toyota Allion маркийн автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоох зорилгоор байгууллагаас 1 сарын хугацаанд шатахуун зарцуулалтын судалгааг хийсэн бөгөөд судалгааны үр дүнгээр уг автомашин орон нутгийн замд 100 км гүйлтэд 8,0 л шатахуун зарцуулсан байна. Иймд автомашины шатахууны бодит зарцуулалтыг үндэслэн Toyota Allion маркийн автомашины үндсэн нормыг 100 км гүйлтэд 8,0 л-ээр тогтоон байгууллагын даргын тушаалаар баталгаажуулан мөрдсөн байна.

Зөвлөмж



Автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг хянахдаа шатахуун зарцуулалтын судалгааг статистик болон туршилт хэмжилтийн аргыг ашиглан хийж автомашины бодит хэмжээг тогтоох шаардлагатай болно.

Шатахуун зарцуулалтын судалгааг хийхэд анхаарах шаардлагатай асуудлууд:  
Үүнд:

- Автомашины техникийн байдлыг оношлох, шатахуун зарцуулалтад нөлөөлөх эвдрэл гэмтэлгүй болохыг тогтоох. Хэрвээ шатахуун зарцуулалтад нөлөөлөх эвдрэл гэмтэл байгаа тохиолдолд шатахуун зарцуулалтын судалгааг явуулахгүй.
- Туршилт хэмжилтийн ажлыг явуулах зам, зай, хугацааг сонгох, туршилтыг ижил нөхцөлд хэд хэдэн удаагийн давтамжтай явуулж шатахуун зарцуулалтын бодит хэмжээг үндэслэлтэй тогтоох.
- Хэмжилтийн үед гарах нөлөөллийг хянах. Тухайлбал туршилтын үед жолоочийн зүгээс шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэх үйлдэл гарч байгаа эсэх, туршилт явуулж байх үед техникийн байдал хэвийн байгаа эсэх, шатахууны хэмжилтийг нарийвчлалтай, алдаагүй байхаар авах зэрэг бодит зарцуулалтыг үнэн зөв гаргахыг тулд судалгаа, туршилт явуулж байгаа ажилтнаас ихээхэн зүйл хамаардаг. Мөн үндсэн норм нь ямар нэгэн нэмэгдэл тооцоогүй норм байдаг тул туршилтыг хүйтний улиралд явуулсан эсэх, авто замын болон тээврийн ажил үйлчилгээнээс хамааралтай нэмэгдлүүд орсон эсэхийг нягтлан тооцох шаардлагатай болдог.

**3. Автомашины үндсэн нормыг нэмэгдүүлэх нөхцөлүүдийг тогтоож олговол зохих шатахууныг тооцох.**



Автомашины үндсэн нормыг нэмэгдүүлэх нөхцөлүүдээс бүх автомашинд заавал тооцох шатахуун зарцуулалтын нэмэгдэл нь хүйтний улирлын нэмэгдэл юм. Өөрөөр хэлбэл автомашин нь дулааны болон хүйтний улиралд мөрдөх шатахуун нормтой байна.

**Жишээ 3** Toyota Allion маркийн автомашины үндсэн нормыг жишээ 2-т 100 км гүйлтэд 7,5 л, уг автомашин Улаанбаатар хотод ажиллах гэсэн өгөгдлийг үндэслэн уг автомашины хүйтний улирлын шатахуун зарцуулалтыг тооцон үзүүлье.

Жишээнд өгсөн өгөгдлөөс уг автомашинд шатахуун зарцуулалтын ямар нэмэгдлүүдийг тооцох боломжтойг тодорхойлъё.

1. Автомашины үндсэн норм  $N_V = 8,0$  л /100 км
2. Уг автомашин Улаанбаатар хотын замд ажиллах бөгөөд авто замын хөдөлгөөний эрчим/түгжрэл/-ийн нэмэгдлийг энэхүү тушаалын 1 дүгээр хавсралтад тооцсон бөгөөд 100 км гүйлтэд 9,0 л байхаар заасан байна. Жишээнд авч байгаа Toyota Allion маркийн автомашины үндсэн норм нь жишиг нормоос зөрүүтэй буюу 8,0 л-ээр тогтоогдсон тул энэхүү тушаалын 2 дугаарын хавсралтын 2,3-т заасан хөдөлгөөний эрчмийн нэмэгдлийг тогтоосон үндсэн норм дээр тооцно.
3. Хүйтний улиралд ажиллах нормыг тооцох. Уг тушаалын 2 дугаар хавсралтын хүйтний улирлын нэмэгдлийн хувь хэмжээг харуулсан хүснэгтээс Улаанбаатар хот нь хүйтний 2 дугаар бүсэд хамаарахаас гадна

29



хүйтний хэмээс хамааруулан тооцох хувь хэмжээ нь 10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15, 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 10 хүртэл 10% , 11 дүгээр сарын 16-наас 2 дугаар сарын 15 хүртэл 20%-иар тогтоосон байна.

Автомашин шатахуун зарцуулалтын нэмэгдлүүдийг тооцох коэффициент;

1. Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний эрчмийн нэмэгдэл;

$$K_T = \frac{\pm \Pi}{100\%} = \frac{20\%}{100\%} = 0.2$$

2. Хүйтний улирлын нэмэгдэл ;

$$K_X = \frac{\pm \Pi}{100\%} = \frac{10\%}{100\%} = 0.1 ;$$

$$K_X = \frac{\pm \Pi}{100\%} = \frac{20\%}{100\%} = 0.2 ;$$

Томьёо 9 нь Автомашинд олговол зохих шатахууны хэмжээг тооцно.

$$Q_n = H_V * \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i)$$

Дээрх томьёогоор уг автомашины 100 км гүйлт дэх үндсэн нормыг хөдөлгөөний эрчмийн нэмэгдэл, хүйтний улирлын 2 дугаар бүсийн 10 хувийн нэмэгдлээр нэмэгдүүлэн тооцвол;

$$Q_n = H_V * \frac{S}{100} * (1 + \sum_{i=1}^n K_i) = H_V * \frac{S}{100} (1 + K_T + K_X) = 8,0 * \frac{100}{100} (1 + 0.2 + 0.1) = 10,4 \text{ л}$$

Хүйтний улирлын 2 дугаар бүсийн 20 хувийн нэмэгдлийг тооцвол;

$$Q_n = H_V * \frac{S}{100} * (\sum_{i=1}^n K_i) = 8,0 \text{ л} * \frac{100}{100} (1+0,2+0,2) = 11,2 \text{ л/100 км}$$

**Жишээ 4** Хүйтний улиралд Улаанбаатар – Зуун мод – Улаанбаатар чиглэлийн 86 км км замд ажилладаг Аэро сити 540 маркийн автобусны шатахуун нормыг тодорхойлбол;



Өгөгдсөн нь  $H_V = 29.5 \text{ л}$ ,  $S = 86 \text{ км}$ ,  $K_T = 0$ ,  $K_X = 0$

1. 10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15, 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 10 хүртэл 10%-иар тооцвол;

$$Q_n = H_V * \frac{S}{100} * (1 + \sum_{i=1}^n K_i) = 29,5 * \frac{86}{100} (1 + 0.1) = 27,91 \approx 30,0 \text{ л/86км}$$

2. 11 дүгээр сарын 16-наас 2 дугаар сарын 15 хүртэл 20%-иар тооцвол;

$$Q_n = H_V * \frac{S}{100} * (1 + \sum_{i=1}^n K_i) = 29,5 * \frac{86}{100} (1 + 0.2) = 30,44 \approx 31,0 \text{ л/86км}$$



**Жишээ 5** Хүйтний улиралд /1 дүгээр сарын 15-ны өдөр/ Улаанбаатар хотоос Архангай аймгийн Цэцэрлэг сум хүртэл 3 тн ачаатай явах Mitsubishi Canter маркийн автомашины олговол зохих шатахуун зарцуулалтыг тооцвол;

Өгөгдсөн:  $N_y = 12.7 \approx 13,0$  л,  $S = 470$  км,  $K_T = 0$ ,  $K_a = 0$ ,  $K_x = 0,2$

$$W = G * S = 470 \text{ км} * 3 \text{ тн} = 1410 \text{ тн.км}$$

Энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын 2,4-т Дизель түлшээр ажилладаг автомашины 100 тн.км тээврийн ажил тутамд 1,725 л шатахуун олгохоор заасан буюу  $N_{тн.км} = 1.725$  л байна.

Дээрх өгөгдлийг үндэслэн томъёо 10-р уг автомашинд олгох шатахуун зарцуулалтын нормыг тооцвол;


$$Q_n = N_y * \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i) + N_{тн.км} * \frac{W}{100} = 13.0 \text{ л} * \frac{470}{100} * (1+0.2) + 1.725 * \frac{1410}{100} = 97.64 \approx 98,0 \text{ л}$$

**Жишээ 6** Дулаан улиралд North Benz загварын ачааны автомашин А маркийн чиргүүлтэй /чиргүүлийн жин 4 тн/ 350 км замд 40 тн-ийн ачааг тээвэрлэх эд олгох шатахуун зарцуулалтын нормыг тооцъё.

Өгөгдсөн нь:  $N_c = 35.0$  л,  $S = 350$  км,  $K_T = 0$ ,  $K_a = 0$ ,  $K_x = 0$ ,  $N_{тн.км} = 1,725$   $G = 4$  тн гэсэн өгөгдлөөс эхлээд уг автомашины чиргүүлтэй ажилласан 100 км сул гүйлтэд зарцуулах шатахууныг хэмжээг тооцвол;

$$N_y = N_c + N_y G = 35.0 \text{ л} + 1,725 * 4 = 41.9 \approx 50 \text{ л/100 км}$$

$$Q_n = N_y * \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i) + N_{тн.км} * \frac{W}{100} = 50 \text{ л} * \frac{350}{100} * 1 + 1,725 * \frac{350 * 40}{100} = 416,5 \text{ л}$$





Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019  
оны 12 сарын 30 -ний өдрийн 390 дугаар  
тушаалын 4 дүгээр хавсралт

## АВТОМАШИНЫ ЭДЭЛГЭЭНИЙ НӨӨЦИЙН ДООД ХЯЗГААР БУЮУ ГҮЙЛТИЙН НОРМ

- 4.1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаарын буюу гүйлтийн нормыг үйлдвэрлэгчийн болон судалгааны үндсэн дээр тогтоосон автомашины эдэлгээний гүйлтийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- 4.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь автомашины эдэлгээний гүйлтийн нормыг ашиглалтын бүс, тээвэрлэлтийн нөхцөл, ачааллаас хамааруулан доорх хувиар хорогдуулан тооцож болно.
- 4.2.1. Авто замын нөхцөлөөс хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь хэмжээ:

№	Авто замын нөхцөл, ердийн хөрсөн зам	Бууруулах хувь хэмжээ
1	Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Завхан, Ховд, Говь-Алтай аймгийн нутагт	10,0
2	Өмнөговь, Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн нутагт	5,0
3	Ашиглалтын хүнд нөхцөлд (уулнаас мод цагаалах, тариан талбайд ажиллах, замгүй газраар хайгуулын ажилд явах, уул уурхайн карьерт ажиллах зэрэг нөхцөлүүд орно)	15,0

- 4.2.2. Автомашины төрөл ачааллаас хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь хэмжээ:

№	Автомашины төрөл, ачаалал	Бууруулах хувь хэмжээ
1	Хоёр голт чиргүүлтэй ажиллавал	15,0
2	Хоёр голт, хоёр чиргүүлтэй ажиллавал	25,0
3	Зүтгэгч автомашин	20,0
4	Өөрөө буулгагч автомашин	15,0
5	Тусгай зориулалтын автомашин	5,0
6	Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний зориулалтын автомашин	25,0
7	Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашин	20,0

Бүртгэлийн дугаар 625<sup>32</sup>  
МОНГОЛ УРСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙАМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуульбар чиглэлийн үйлчилгээний газрын үсэг  
19.12 сарын 30

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ний өдрийн 30 дугаар тушаалын 5 дугаар хэсрэлт

### АВТОМАШИНЫ СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЭДЭЛГЭЭНИЙ ДООД ХЯЗГААР НОРМ

- 5.1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- 5.1.1. Резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг уур амьсгал, авто замын нөхцөлийг харгалзан тогтоосон ашиглалтын бүсээс хамааруулан резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг доорх хувиар хорогдуулан тооцож болно.


Бүсийн дугаар	Тухайн бүсэд багтах аймгууд	Эдэлгээний нөөцийн доод хязгаарыг хорогдуулах хувь
I бүс	Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул, Төв, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод, Хэнтий	-
II бүс	Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл	10,0

- 5.1.2. Мод бэлтгэх карьерын нөхцөл нь ашиглалтын бүсийн ялгаанаас хамаарахгүйгээр хоёр бүсэд аль алинд нь ижил байх учир энэ нөхцөлд резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормын тооцоонд ашиглалтын бүсийн хорогдуулах хувийг хэрэглэхгүй.
- 5.1.3. Автомашины тээвэрлэлтийн нөхцөлийг харгалзан резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг доорх хувиар бууруулан хэрэглэж болно.

№	Автомашины тээвэрлэлтийн нөхцөл	Эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь
1	Байнга нэг чиргүүлтэй ажилладаг ачааны автомашинд	15,0
2	Мод бэлтгэл, уул уурхайн карьерын нөхцөлд тогтмол ажилладаг ачааны автомашинд	30,0
3	Байнга 2 чиргүүлтэй буюу 10 тн-оос дээш даацтай, олон голт чиргүүл /трейллер/ чирдэг автомашинд	25,0
4	Бартаа саад ихтэй авто замын онцгой хүнд нөхцөлд ажилладаг цагдаагийн байгууллагын автомашинд	25,0

- 5.1.4. Зарим үйлдвэрлэгчийн резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын нормыг хүснэгт 5.3-т үзүүлэв.

33



Хүснэгт 5.3. РЕЗИН ДУГУЙН ЭДЭЛГЭЭНИЙ ГҮЙЛТИЙН ДООД ХЯЗГААР

№	Резин дугуйн төрөл, хэв маяг, хэмжээ загвар	Эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг /мян км/												
		DUNLOP	MICHLEN	BRIDGESTONE	YOKOHAMA	TOYO	HANKOOK	КУМНО	НОКИАН	ВАРИМ	ВАРНАУЛ	УАРОСЛАВИ	КАМА	OMSKSHINA
<b>СУУДЛЫН АВТОМАШИН</b>														
<b>R12</b>														
1	145/70													
2	145/80	35.0	35.0	35.0	35.0	32.0	32.0	32.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0
3	145 SR (8PR) даац													
<b>R13</b>														
4	155/70													
5	155/80													
6	165/70													
7	165/80													
8	175/65													
9	175/70													
10	175/80	45.0	45.0	45.0	45.0	42.0	42.0	42.0	42.0	42.0	42.0	41.0	41.0	40.0
11	185/65													
12	185/70													
13	195/60													
14	195/65													
15	205/60													
<b>R14</b>														

МОНГОЛ УЛСЫН  
 ДАМ, ТЭЭВЭРИЙН ЭЗЭЛЭГЧИЙН  
 ХҮҮЛБАР ҮНДЭН  
 Хуульбар олгогчийн зөв гүйцэтгэлтэй байхыг  
 19 *6/25* 2012 оны 30

625  
 19 *6/25* 2012 оны 30

Хуульбар олгогчийн зөв гүйцэтгэлтэй байхыг  
 ДАМ, ТЭЭВЭРИЙН ЭЗЭЛЭГЧИЙН  
 ХҮҮЛБАР ҮНДЭН  
 19 *6/25* 2012 оны 30





79	205/60																					
80	205/65																					
81	205/70																					
82	215/50																					
83	215/55																					
84	215/60																					
85	215/65																					
86	215/70																					
87	225/45																					
88	225/50																					
89	225/55																					
90	225/60																					
91	225/65																					
92	225/70																					
93	245/40																					
94	245/45																					
95	245/50																					
96	245/55																					
97	245/60																					
98	245/65																					
99	265/35																					
100	265/40																					
101	265/45																					
102	265/50																					
103	265/55																					
104	265/60																					

AM 1330  
 XY...  
 19 12 30

**R16 (Jeep)**

105	225/75																					
106	237/70																					
107	235/75																					
108	235/80																					
109	235/85																					
110	245/70	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0	70.0
111	245/75																					

MA...  
 37  
 390

625  
 19 12 30



АЧААНЫ АВТОМАШИН БОЛОН АВТОБУС												
145	265/70											
146	275/55											
147	275/60											
148	275/65											
149	275/70											
150	145/80 R12 (6PR, 8PR)	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	30.0	30.0
151	145/SR 12 (6PR, 8PR)	38.0	37.0	35.0	35.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0
152	6.45 R13	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
153	8.40 R15	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0
154	8.40 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
155	9.00 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
156	10.00 R20	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0
157	11.00 R20	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0
158	12.00 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
159	14.00 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
160	12.00 R18	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
161	13.00 R18	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
162	12.00 R22.5	70.0	70.0	70.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	60.0	60.0	60.0
163	335/80 R20	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0

МОНГОЛ УИДЭГ  
 ЗАМ, ТЭЭВЭРИЙН ТЭГЭЛЭЛЭГ  
 ХҮҮЛБАР ТӨСВИ  
 Хуульбар орлогын үзүүлэлт

625  
 ЗАМ, ТЭЭВЭРИЙН ТЭГЭЛЭЛЭГ  
 ХҮҮЛБАР ТӨСВИ  
 Хуульбар орлогын үзүүлэлт  
 19-12-19



МОНГОЛ УИДЭГ  
 ЗАМ, ТЭЭВЭРИЙН ТЭГЭЛЭЛЭГ  
 ХҮҮЛБАР ТӨСВИ  
 Хуульбар орлогын үзүүлэлт  
 30



- 5.2. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины зай хураагуур буюу аккумуляторын эдэлгээний хугацааны нөөцийн доод хязгаарын нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- 5.2.1. Автомашины зай хураагуур буюу аккумуляторын эдэлгээний хугацааны доод хязгаарын үндсэн нормыг автомашины тусгай төхөөрөмж нь хөдөлгүүр унтраасан үед зай хураагуураас тэжээл авч ажиллах зайлшгүй шаардлагатай /GPS, дохиолол, тог хувиргагч гэх мэт/ тусгай үүрэг чиглэлийн автомашинуудад төхөөрөмжийн тооноос хамааруулан зай хураагуурын эдэлгээний нормыг 50 хүртэл хувиар бууруулан тооцож болно.
- 5.2.2. Зарим үйлдвэрлэгчийн зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарыг хүснэгт 5.4-т үзүүлэв.

**Хүснэгт 5.4. ЗАЙ ХУРААГУУРЫН ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААНЫ ДООД ХЯЗГААР**

№	Зай хураагуурын төрөл, ампер цаг	Үйлдвэрлэсэн улс	Эдэлгээний хугацааны доод хязгаар, /сараар/
1	Akuma-66 түүний төрлүүд	Чех	32
2	Grand-Plus, Duples-Норресег түүний төрлүүд	Герман	32
3	Declor-DE90R, 80D26R, 95D31R түүний төрлүүд	Солонгос	43
4	Yusimi түүний төрлүүд	Солонгос	36
5	Solite түүний төрлүүд	Солонгос	30
6	Panasonic түүний төрлүүд	Япон	36
7	HITACHI түүний төрлүүд	Япон	36
8	FIAMM түүний төрлүүд	Итали	42
9	DOUGLAS-675, TURBO PLUS-75, American түүний төрлүүд	АНУ	42
10	6СТ түүний төрлүүд	ОХУ	24
11	ROCKET түүний төрлүүд	ОХУ	28
12	6Q түүний төрлүүд	Хятад	21
13	Loingjiang түүний төрлүүд	Хятад	18
14	ТСВО түүний төрлүүд	Хятад	18



Хүснэгт 5.5. Автомашины үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний доод хязгаар

Эд анги	Суудлын автомашин (Хөдөлгүүрийн эзэлхүүнээр см³)		Автобус (баглаамж уртаар)				Ачааны автомашин (даацаар)				/МЯН. КМ/
	Бага эзэлхүүнтэй 1.8л хүртэл	Дунд эзэлхүүнтэй 1.8-3.5 л	Онцгой бага 5 м хүртэл	Бага баглаамжтай 6-7.5 м	Дунд баглаамжтай 8-9.5 м	Их баглаамжтай 10.5-12.0 м	Онцгой бага даацтай 0.3-1.0 тн хүртэл	Бага даацтай 1.0-3.0 тн хүртэл	Дунд даацтай 3.0-5.0 тн хүртэл	Их даацтай 5.0-8.0 тн хүртэл	
<b>1</b>											
<b>1.1. Бензин</b>											
-	-	150	125	150	200	250	125	150	200	200	250
-	-	70	70	70	70	80	70	70	70	80	80
-	-	120	80	80	100	120	80	100	120	120	120
-	-	150	70	70	80	200	70	80	100	150	200
-	-	60	60	60	60	60	60	60	60	60	60
-	-	60	60	60	60	60	60	60	60	60	60
<b>1.2. Дизель</b>											
-	-	125	125	150	200	200	125	150	200	150	200
-	-	60	60	60	80	80	60	60	80	80	80
-	-	80	80	90	90	120	120	150	150	150	150
-	-	30	30	50	50	50	30	30	50	50	50
-	-	80	80	80	80	80	80	80	80	80	80
-	-	50	60	60	60	60	60	60	60	60	60
<b>1.3. Авцуулах холбоо</b>											
-	-	125	125	125	150	150	125	125	150	150	150
-	-	60	60	60	80	80	60	60	80	80	100
<b>2</b>											
<b>2.1. Механик</b>											
-	-	125	125	150	200	250	125	150	200	200	250
-	-	80	80	80	100	120	90	100	120	200	200
<b>2.2. Автомат</b>											
-	-	150	200	200	200	250	250	200	200	200	200
-	-	100	100	100	100	150	150	100	100	100	100
<b>3</b>											
<b>Хөдөлгүүр, авцуулах холбоо</b>											
<b>ХУРДНЫ ХАЙРЦАГ</b>											
<b>Хөтөлгөч ба урд тэнхлэг</b>											
-	-	250	200	200	200	250	200	200	200	200	200

2019.12.30

ХУУЛЬ

41

Хүснэгт 5.5. Автомашины үндсэн агрегат, зангилаануудын эдлэлээний доод хязгаар

Эд анги	Суудлын автомашин (Хөдөлгүүрийн эзэлхүүнээр см <sup>3</sup> )		Автобус (багаамж уртаар/				Ачааны автомашин /даацаар/				/МЯН. КМ/	
	Бага эзэлхүүнтэй 1,8л хүртэл	Дунд эзэлхүүнтэй 1,8-3,5 л	Онцгой бага 5 м хүртэл	Бага багаамжтай 6-7,5 м	Дунд багаамжтай 8-9,5 м	Их багаамжтай 10,5-12,0 м	Онцгой бага даацтай 0,3-1,0 тн хүртэл	Бага даацтай 1,0-3,0 тн хүртэл	Дунд даацтай 3,0-5,0 тн хүртэл	Их даацтай 5,0-8,0 тн хүртэл		Онцгой их даацтай 8,0 тн-дээш
	ХӨДӨЛГҮҮР, АВЦУУЛАХ ХОЛБОО											
1	ХӨДӨЛГҮҮР, АВЦУУЛАХ ХОЛБОО											
1.1. Бензин												
- Блок, тахир гол	150	125	150	200	250	125	150	200	200	250		
- Тэжээл форсунк	70	70	70	70	80	70	70	70	70	80	80	
- Усны насос	120	80	80	100	120	80	100	100	120	120	120	
- Тосны насос	150	70	70	80	200	70	80	100	100	150	200	
- Давьд агуу насос	60	60	60	60	60	60	60	60	60	60	60	
- Стартер	60	60	60	60	60	60	60	60	60	60	60	
1.2 Дизель												
- Блок, тахир гол	150	125	150	200	250	125	150	200	200	250		
- Карбюратор	60	60	60	80	80	60	60	80	80	80	80	
- Инжектор цацагч	80	80	80	90	120	80	90	100	120	120	120	
- Очлуур	30	30	30	50	50	30	30	50	50	50	50	
- Динам	80	80	80	80	80	80	80	80	80	80	80	
- Стартер	50	60	60	60	60	60	60	60	60	60	60	
1.3 Авцуулах холбоо												
- Шахах эзэрэнхий	125	150	125	150	150	125	125	150	150	150	150	
- Хөтлөгдөгч эзэрэнхий	60	80	60	80	100	60	60	80	80	100	100	
2	ХҮРДНЫ ХАЙРЦАГ											
2.1 Механик												
- Их бие, таг арьс	125	150	125	200	250	125	150	200	200	250		
- Араа голууд	80	80	80	100	120	90	100	120	120	200	200	
2.2 Автомат												
- Их бие, таг арьс	150	200		200	250							
- Араа голууд	100	100		100	150							
3	ХӨТЛӨГЧ БА УРД ТЭНХЛЭГ											
- Урд хөтлөгч тэнхлэгийн арьс хөндлөвч	250	200		200								

3AM ТЭГЭЭН  
ХҮҮЛЭЭН  
19 12 30

Урьдчилсан  
ХҮҮЛЭЭН  
41

ХҮҮЛЭЭН  
41